

ХААН СОЁМБО АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Нийтийн номын сангийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/48/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Хаан соёмбо аудитын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитор:
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	12
3.6.3 Нэмэлт төсөв.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт	14
5.2 Албан шаардлага.....	14
5.3 Зөвлөмж	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/149
танай _____ -ны № _____ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙТИЙН
НОМЫН САНГИЙН ЗАХИРАЛ
Э.ДАВААЧУЛУУН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Нийтийн номын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Нийтийн номын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд мөнгөн хөрөнгийн данс 11.7 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Соёлын сайдын А/125 тоот тушаалын дагуу “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд 2022” арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 онд 1 зорилтын хүрээнд 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласнаас 92.8 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,698,039.73</u>	<u>33,564,025.42</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	12,936,521.42
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	12,936,521.42
3121	Төгрөг	00.00	12,936,521.42
31211	Төрийн сангийн харилцах	00.00	12,936,521.42
33	АВЛАГА	2,219,157.73	2,191,672.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,191,672.00	2,191,672.00
335	Бусад авлага	27,485.73	00.00
3351	Байгууллагаас авах авлага	27,485.73	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,478,882.00	18,435,832.00
354	Хангамжийн материал	8,478,882.00	18,435,832.00
35410	Бичиг хэргийн материал	230,800.00	968,800.00
35420	Аж ахуйн материал	4,941,250.00	6,778,450.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	900,000.00
35450	Барилгын засварын материал	00.00	4,174,500.00
35470	Бусад хангамжийн материал	3,306,832.00	5,614,082.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,378,787,114.80</u>	<u>1,340,979,693.44</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,378,787,114.80	1,340,979,693.44
392	Биет хөрөнгө	1,266,682,114.80	1,224,790,693.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,142,316,848.14	1,142,316,848.14
39202	Хуримтлагдсан элэгдэл	-98,061,385.32	-130,748,513.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,000,000.00	20,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-3,999,999.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	77,022,299.00	88,197,099.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-21,753,300.10	-39,856,022.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,056,349.20	42,056,349.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,825,468.51	-29,689,838.67
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,085,950.00	5,085,950.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,971,700.37	-3,532,200.57
39217	Ном	126,812,522.76	134,961,022.76
393	Биет бус хөрөнгө	112,105,000.00	113,188,999.96
39301	Програм хангамж	2,080,000.00	3,580,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-416,000.04
39303	Бусад биет бус хөрөнгө	110,025,000.00	110,025,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,389,485,154.53</u>	<u>1,371,543,718.86</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>9,572.01</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,572.01	00.00
413	Өглөг	9,572.01	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	9,572.01	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,386,475,582.53</u>	<u>1,371,543,718.86</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,386,475,582.53	1,371,543,718.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	811,507,753.90	811,507,753.90
51101	Өмч: - төрийн	811,507,753.90	811,507,753.90
512	Хуримтлагдсан үр дүн	-115,618,697.83	-130,550,561.50
51210	Өмнөх үеийн үр дүн	-115,618,697.83	-115,618,697.83
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-14,931,863.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	690,586,526.45	690,586,526.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,386,485,154.53</u>	<u>1,371,543,718.86</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	210,807,022.50	313,917,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	209,205,022.50	14,737,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,197,622.50	14,442,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,197,622.50	14,442,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	451,800.00	768,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	10,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,745,822.50	3,674,000.00
122	Тусламжийн орлого	198,007,400.00	295,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	295,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,602,000.00	299,180,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	55,682,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	55,682,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,602,000.00	200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,250,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	352,000.00	200,000.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	00.00	10,000,000.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	243,297,100.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	233,297,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	207,145,173.21	329,487,183.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	207,145,173.21	329,487,183.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	191,343,673.21	328,485,932.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	113,762,734.59	168,411,805.87
210101	Үндсэн цалин	109,709,805.59	139,273,889.34
210102	Нэмэгдэл	2,882,929.00	15,164,092.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,170,000.00	12,489,000.00
210104	Урамшуулал	00.00	1,484,824.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,220,701.41	27,520,246.67
210201	Тэтгэврийн даатгал	11,502,998.06	20,514,030.85
210202	Тэтгэмжийн даатгал	1,275,362.32	1,822,343.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	866,460.73	1,409,787.12
210204	Ажилгүйдлийн даатгал	209,956.66	313,594.28
210205	Эрүүл мэндийн даатгал	2,365,923.64	3,460,490.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,077,262.00	41,316,615.46
210301	Гэрэл, цахилгаан	892,213.00	2,385,047.76
210302	Түлш, халаалт	23,561,011.00	37,886,782.00
210303	Цэвэр, бохир ус	624,038.00	1,044,785.70
2104	Хангамж, бараа материалын зардал	4,610,958.00	5,841,479.70
210401	Бичиг хэрэг	2,519,900.00	2,572,150.00
210402	Тээвэр, шатахуун	1,002,000.00	744,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	875,858.00	1,658,929.70
210404	Ном, хэвлэл	13,200.00	783,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00	83,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	693,300.00	6,172,975.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250,000.00	00.00
210604	Урсгал засвар	443,300.00	6,172,975.00
2107	Томилолт, зочны зардал	200,000.00	1,834,000.00
210702	Дотоод албан томилолт	200,000.00	1,834,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,228,200.00	16,063,593.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	14,863,593.00

Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	42,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,831,000.00	1,200,000.00
210807	Газрын төлбөр	202,950.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,550,517.21	61,325,216.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,056,475.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,550,517.21	59,268,741.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,801,500.00	1,001,251.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,801,500.00	360,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,384,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	416,700.00	360,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	641,251.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	641,251.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,661,849.30	-15,569,883.63
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,661,849.30	-15,569,883.63

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	811,507,753.91	690,586,526.45	-171,356,430.35	1,330,737,850.01
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	811,507,753.91	690,586,526.45	-171,356,430.35	1,330,737,850.01
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	24,970,561.28	24,970,561.27
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	811,507,753.90	690,586,526.45	-115,618,697.83	1,386,475,582.52
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	811,507,753.90	690,586,526.45	-115,618,697.83	1,386,475,582.52
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	811,507,753.90	690,586,526.45	-115,618,697.83	1,386,475,582.52
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-15,569,883.63	-14,931,863.67
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	811,507,753.90	693,586,526.45	-131,188,581.46	1,371,543,718.85

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төгрөгөөр/
			Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	61,729,900.00	309,948,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	61,729,900.00	10,768,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	253,600.00	10,768,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	253,600.00	10,768,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	253,600.00	768,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	10,000,000.00
122	Тусламжийн орлого	61,476,300.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	299,180,000.00

Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	55,682,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	55,682,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	200,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	200,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	10,000,000.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	00.00	10,000,000.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	233,297,100.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	233,297,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	19,962,248.00	288,236,878.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,962,248.00	288,236,878.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,962,248.00	287,195,626.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,447,757.00	173,035,926.97
210101	Үндсэн цалин	10,998,603.00	140,388,346.44
210102	Нэмэгдэл	1,874,154.00	16,288,756.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	575,000.00	14,873,999.70
210104	Урамшуулал	00.00	1,484,824.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,802,300.00	22,795,639.84
210201	Тэтгэврийн даатгал	1,243,389.72	15,789,424.02
210202	Тэтгэмжийн даатгал	142,877.57	1,822,343.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	110,942.07	1,383,995.08
210204	Ажилгүйдлийн даатгал	27,735.50	339,386.32
210205	Эрүүл мэндийн даатгал	277,355.14	3,460,490.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,712,191.00	41,186,817.47
210301	Гэрэл, цахилгаан	00.00	2,255,249.77
210302	Түлш, халаалт	4,712,191.00	37,886,782.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,044,785.70
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	10,136,949.70
210401	Бичиг хэрэг	00.00	2,316,350.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	744,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	1,923,999.70
210404	Ном, хэвлэл	00.00	4,979,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	173,400.00
2105	Нормативт зардал	00.00	255,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	255,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	11,760,975.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	120,000.00
210604	Урсгал засвар	00.00	11,640,975.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	1,834,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	1,834,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	18,001,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	16,801,550.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	8,188,018.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	8,188,018.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	1,041,251.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	641,251.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	641,251.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	41,767,652.00	21,711,421.42
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	8,774,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	8,774,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	8,774,900.00

Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	8,774,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-8,774,900.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	41,767,652.00	12,936,521.42
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	41,767,652.00	12,936,521.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	249,065,400.00	231,128,878.59	-17,936,521.41	92.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	249,065,400.00	231,128,878.59	-17,936,521.41	92.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	248,381,400.00	230,728,878.59	-17,652,521.41	92.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	169,181,700.00	168,880,095.05	-301,604.95	99.82
210101	Үндсэн цалин	127,772,200.00	136,607,708.05	8,835,508.05	106.92
210102	Нэмэгдэл	26,965,300.00	15,913,563.30	-11,051,736.70	59.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,177,100.00	14,873,999.70	7,696,899.70	207.24
210104	Урамшуулал	7,267,100.00	1,484,824.00	-5,782,276.00	20.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,835,200.00	22,272,240.84	-562,959.16	97.53
210201	Тэтгэврийн даатгал	16,007,900.00	15,435,748.54	-572,151.46	96.43
210202	Тэтгэмжийн даатгал	1,706,800.00	1,780,087.98	73,287.98	104.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,365,500.00	1,350,190.38	-15,309.62	98.88
210204	Ажилгүйдлийн даатгал	341,400.00	330,835.14	-10,564.86	96.91
210205	Эрүүл мэндийн даатгал	3,413,600.00	3,375,378.80	-38,221.20	98.88
2104	Хангамж, бараа материалын зардал	11,814,800.00	10,741,949.70	-1,072,850.30	90.92
210401	Бичиг хэрэг	1,200,400.00	2,316,350.00	1,115,950.00	192.96
210402	Тээвэр, шатахуун	514,400.00	744,000.00	229,600.00	144.63
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,050,000.00	1,923,999.70	873,999.70	183.24
210404	Ном, хэвлэл	8,550,000.00	4,979,200.00	-3,570,800.00	58.24
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	778,400.00	278,400.00	155.68
2105	Нормативт зардал	390,300.00	255,750.00	-134,550.00	65.53
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	390,300.00	255,750.00	-134,550.00	65.53
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	579,000.00	555,275.00	-23,725.00	95.90
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	121,000.00	120,000.00	-1,000.00	99.17
210604	Урсгал засвар	458,000.00	435,275.00	-22,725.00	95.04
2107	Томилолт, зочны зардал	1,862,000.00	1,834,000.00	-28,000.00	98.50
210702	Дотоод албан томилолт	1,862,000.00	1,834,000.00	-28,000.00	98.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,251,700.00	18,001,550.00	-8,250,150.00	68.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,051,700.00	16,801,550.00	-8,250,150.00	67.07

Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,200,000.00	1,200,000.00	00.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15466700.00	8188018.00	-7,278,682.00	52.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,466,700.00	8,188,018.00	-7,278,682.00	52.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	684,000.00	400,000.00	-284,000.00	58.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	684,000.00	400,000.00	-284,000.00	58.48
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	684,000.00	400,000.00	-284,000.00	58.48
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	249,065,400.00	244,065,400.00	-5,000,000.00	97.99
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	249,065,400.00	233,297,100.00	-15,768,300.00	93.67
131001	Улсын төсвөөс санхүүжих	249,065,400.00	233,297,100.00	-15,768,300.00	93.67
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	10,768,300.00	10,768,300.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	768,300.00	768,300.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	10,000,000.00	10,000,000.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	12,936,521.41	12,936,521.41	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	00.00	100.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	00.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	16.00	16.00	00.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	00.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,768,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,768,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,768,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,958,400.00
210404	Ном, хэвлэл	3,958,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,809,900.00
210604	Урсгал засвар	6,809,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,768,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,768,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,768,300.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Нийтийн номын сан нь оюуны бүтээлийг цуглуулан баяжуулж, хадгалан хамгаалж, нээлттэй хүртээмжтэй мэдлэг мэдээллээр нийтэд үйлчлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Соёлын сайдын эрхлэх үрээний харьяа улсын болон орон нутгийн эх үүсвэрээр санхүүждэг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага юм. зорилготой ажилладаг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагад мөрдөгдөх дараах хууль тогтоомжуудад тайлант онд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15.6 төгрөгөөр буюу 1.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Дансны авлага	2.2	2.2	-
Бараа материал	8.5	18.4	9.9
Үндсэн хөрөнгө	1,378.8	1,341.0	(37.8)
Биет бус хөрөнгө	112.1	113.2	1.1
Нийт хөрөнгө	1,389.5	1,371.5	(18)
Дансны өглөг	9.6	-	(9.5)
-төрийн	811.5	811.5	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	690.6	690.6	-
Хуримтлагдсан үр дүн	(115.6)	(130.5)	(14.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,386.5	1,371.5	(15)

Дээрх хүснэгтээс харахад бараа материал 9.9 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс 38.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хуримтлагдсан үр дүн 15.6 сая төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 510.6 сая, нийт зарлагыг 510.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 261.5 сая төгрөгөөр бууруулж, 249.1 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр улсын төсвөөс 233.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 10.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 231.1 сая төгрөг буюу 92.8 хувьтай байгаа ба 0.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал

/сая төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71702	Соёл урлаг	249.1	231.1	(18)	92.8
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	248.4	230.7	(17.6)	92.9
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	0.7	0.4	(0.3)	58.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллага нь 9.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг авсан байна.

Үүнээс 3.0 сая төгрөгийг хангамж, бараа материалын зардалд, 6.8 сая төгрөгийг эд хогшил, урсгал засварын зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийтийн номын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн чанарын хяналт, ахлах аудитор Н.Бадамханд гүйцэтгэж, хяналтыг анхан шатанд Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 4.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 2.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 онд цалингийн зардлаас бусад 5 саяаас дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээнээс 80.5 сая төгрөгийн 7 орлогын мэдээллийг огт мэдээллээгүй бусад мэдээллийг цаг тухайд нь оруулсан байна.

Зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд цаг тухай бүрд нь мэдээллийг оруулж байх.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайланд онд тус байгууллагад завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөл, хууль дүрэм хэрэгжүүлэн ажиллахтай холбоотой 2 зөрчилд 2 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	1.1	2	1.1	100
Нийт дүн	2	1.1	2	1.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 82.7 сая төгрөгийн зөрчил илэрч нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

5.3 Зөвлөмж

1. Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Өмнөх онд үүссэн 2.2 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж:

Өмнөх оны авлагыг бүрэн барагдуулж, дахин нэмэгдүүлэхгүй ажиллах

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 оны цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй орлого, зарлагын гүйлгээнээс 80.5 сая төгрөгийн мэдээллийг огт оруулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5 дахь заалттай нийцэхгүй байгаа ба нийцсэн бөгөөд зохистой гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь ил тод мэдээлж байх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх оны авлагыг барагдуулаагүй	1	2.2					1	2.2				
Дүн	1	2.2					1	2.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Мэдээлээгүй	7	80.5						1	80.5

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АХЛАХ АУДИТОР

Б.ДАВААНЫМ ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

ЧАНАРЫН ХЯНАЛТ, АУДИТОР

Х.ДИИМАА

Н.БАДАМХАНД

